

# “ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

## ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04-р дугаар сарын 28

№ 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн тухай  
болон хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, компанийн дүрмийн 7.4 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 53'517 ширхэг нэгж хувьцаа эзэмшигч биеэр оролцож байгаа нь нийт саналын эрхтэй хувьцааны 90,47 % болж байна.

Хоёр. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, компанийн дүрмийн 7.4 дахь хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 90,47 хувийг эзэмшигч хуралд оролцож байгааг үндэслэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТЗОРИГ/

# “ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

## ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04-р дугаар сарын 28

№ 04

Улаанбаатар хот

“ТЭЭВЭР АЧЛАЛ” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас

ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сайшаасугай.

Хоёр. Компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд “ЭС ЭМ” аудитын компанийн хийсэн аудитын дүгнэлтийг сайшаасугай.

Гурав. Компанийн үйл ажиллагааг эрчимжүүлж санхүүгийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Дөрөв. Компанийн санхүүгийн чадавхыг дээшлүүлж, компанийн ажилтан, албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг компанийн гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Тав. Компанийн хэлбэрийг өөрчлөх талаар дахин судлах үүргийг компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТЗОРИГ/